

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн ерөнхийлөн захирагч болон Дундговь аймгийн Засаг даргын хооронд хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, санхүүжилтийн талаар 2022 онд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан

2022.12.19

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Аймгийн Засаг даргын хооронд хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, санхүүжилтийн талаар 2022 онд байгуулсан гэрээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээг хийж, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж удаашралтай байгаа заалтуудыг эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл өгч ажилласан.

### НЭГ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЯВЦ, ҮР ДҮН

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Аймгийн Засаг даргын хооронд хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, санхүүжилтийн талаар 2022 онд байгуулсан гэрээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.1-т заасан арга зүйгээр Нийгмийн бодлогын хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Аймгийн засаг дарга Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын сайдтай 2022 онд байгуулсан хөтөлбөр, санхүүжилтийн гэрээний нийт 63 үзүүлэлтийн хэрэгжилт 88.3 хувьтай байна.

| Бүлгийн дугаар | Бүлгийн агуулга                                                                                                                                                                                                                                      | Хөтөлбөрийн арга хэмжээний тоо | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /мян,төг/ | Бүлгийн үнэлгээ | Үнэлгээ |
|----------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------|---------------------------------------|-----------------|---------|
| 1              | Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.                                                                             | 25                             | 900709.8                              | 71.5%           | 83.6%   |
| 2              | Нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломж бүхий олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжинэ.                                                                                | 9                              | 43303738.4                            | 94.1%           |         |
| 3              | Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ. | 9                              | 889300.0                              | 71.3%           |         |
| 4              | Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалыг                                                                                                                                                                                                        | 12                             | 694461.4                              | 97.5%           |         |

|         |                                                                                                                                       |    |               |      |       |
|---------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|---------------|------|-------|
|         | боловсронгуй болгож, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн хөдөлмөр, эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг тууштай бууруулна. |    |               |      |       |
| 5       | Орон нутгийн засаг даргаас үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ                                                                       | 1  | 79500.0       | 100% | 93%   |
| 6       | Орон нутгийн засаг даргаас тухайн орон нутгийн хүн амын нийгмийн бүлгүүдэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж ажиллах                       | 7  | -             | 86%  |       |
| Нэгтгэл |                                                                                                                                       | 63 | 45.867.709.60 |      | 88.3% |

Аймгийн засаг дарга Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын сайдтай 2022 онд байгуулсан гэрээний Засаг даргын хүлээх 72 үүргийг 88.4 хувьтай хэрэгжүүлсэн байна.

| № | Засаг даргын хүлээх үүргийн тоо | Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн хувь |
|---|---------------------------------|--------------------------------|-------------------|
| 1 | 63                              | 72                             | 88.4              |

## ХОЁР. ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭЭС ДАРААХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ГЭЖ ҮЗЭВ.


Ид шидийн орны барилгын ажил энэ оны 4 дүгээр сард эхэлж, 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр тус төв нээлтээ хийж, “Ид шидийн орон” хүүхэд хөгжил хамгааллын төвтэй боллоо.

Энэхүү хүүхдийн хөгжил-хамгааллын жишиг төвийг байгуулахад 1.5 тэрбум төгрөгөөр бүтээн байгуулсан бөгөөд нутгийн иргэд, малчид, хүүхэд багачууд, Дундговийн гаралтай дэлхий өнцөг булан бүрд сурч, хөдөлмөрлөж, ажиллаж амьдарч байгаа хүн бүхний халуун сэтгэлийн хандиваар баригдсан. Төр-Төрийн бус байгууллага-Иргэд хамтран ажиллаж, бүтээн байгуулалт хийсэн анхны тохиолдол болж буй юм.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас газар, дэд бүтцийн асуудлыг 100 хувь шийдвэрлэсэн бөгөөд “Ид шидийн орон” хүүхэд хөгжил, хамгааллын төвийн үйл ажиллагаанд 55.4 сая төгрөгийг засаг даргын нөөцөөс дэмжлэг үзүүлж, цаашид үйл ажиллагааны урсгал зардлыг бүрэн хариуцаж ажиллахаар болж, 2023 оны тогтмол болон үйл ажиллагааны зардал болох 230,0 сая төгрөгийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталлаа.



Аймгийн хүүхдийн 13 дугаар чуулган зохион байгуулж, үйл ажиллагааны зардалд 2.8 сая төгрөг, байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн зөвлөгөөнд 860.0 төгрөг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс, Хүүхдийн паркт 4 төрлийн тоглоом 90.8 сая төгрөгийг аймгийн орон нутаг хөгжүүлэх сангаас, хүүхдийн зуслангийн засварт 160.0 сая төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр зорилтот бүлгийн 150 хүүхдэд 7.5 сая төгрөгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэж дэмжлэг үзүүллээ.



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгодог "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн санхүүгийн дэмжлэгт 13 иргэнийг хамруулж 96 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.


Хөгжлийн бэрхшээлтэй хүний бүсийн хөгжлийн төвийн барилгыг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр "Хөх хайрхан трейд" ХХК барьж ашиглалтад оруулахад бэлэн болоод байна.






Хөгжлийн бэрхшээлтэй хүний "Боломжийг бүгдэд" 2 сарын аян зохион байгуулж, тэдний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах ажлыг бүх сум, агентлагаар хийж 48 иргэний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг 110 байгууллага худалдан авалт хийж, 44,7 сая төгрөгийн борлуулалтын орлого оруулан дэмжлэг үзүүллээ. Тэдний эрхийн өдрөөр чуулган зохион байгуулж, 120 гаруй хүн хамруулж, тулгамдсан асуудлаа хэлэлцэн, ирэх оны төлөвлөлтөө зөвлөлдөж, энэ үеэр хувиараа хөдөлмөр эрхлэгчид үзэсгэлэн гаргаж борлуулалт хийлээ.



Ахмадын спортын 3 дугаар наадамд 14 сумаас 176 ахмад тамирчид спортын 6 төрлөөр 54 багц медалийн төлөө хурд хүч ,авьяас, ур чадвараа сорин өрсөлдөж аймгийн аваргуудаа тодрууллаа.



Ахмадын ордон ашиглалтад орж байна.



Ахмадын ордны барилгын ажил дуусаж, хүлээлгэн өгөхөд бэлэн болж, тогтмол болон урсгал, үйл ажиллагааны зардлыг 2022 оны 98 сая төгрөг, 2023 оны зардал 108 сая төгрөгийг аймгийн ИТХ-ын төлөөлөгчид шийдвэрлэж өглөө.

### ГУРАВ. ДУТАГДАЛТАЙ ХЭРЭГЖСЭН АРГА ХЭМЖЭЭ:

“Хохирогч хамгаалах түр хамгаалах байрны стандарт /MNS 6040:2019/- г хэрэгжүүлэх, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, санхүүжилтийг орон нутгийн төсөвт тусгах”, “Гэр бүлийн хохирогчийг хамгаалах “Түр хамгаалах байр”-ыг стандартын дагуу байгуулж, ажиллуулах” арга хэмжээ 2021 онд хөрөнгө санхүүгийн асуудлаас болж дутагдалтай хэрэгжсэн ч 2023 оны төсөв Түр хамгаалах байртай болох зардалд 250.0 сая төгрөгийг тусгаад байна.

“Хүүхэд харах үйлчилгээг хэрэгжүүлнэ” гэсэн арга хэмжээний хүрээнд Байгууллагын пэйж хуудсаар дамжуулан хүүхэд харах үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдэд хүсэлтийг хүлээж авахаар 2 удаагийн давтамжтайгаар зар хүргэсэн боловч иргэдээс санал ирээгүй. Аймгийн хэмжээнд хүүхэд харах үйлчилгээ эрхэлдэг иргэн, аж ахуй нэгж байхгүй.

“Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, Залуучуудын салбар зөвлөлийн төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган тайлагнах” арга

хэмжээний хүрээнд Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, гишүүдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Залуучуудын салбар зөвлөлийн 34 гишүүнд "Залуучуудын салбар зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах нь" сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтын үеэр соёлын байгууллагуудын дэргэдэх Залуучуудын хөгжлийн зөвлөлийг байгуулан батламжийг гардуулан өглөө. Залуучуудын салбар зөвлөлийн хуралдааныг 1 удаа зохион байгуулсан нь зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

"Залуучуудын хөгжлийг дэмжих орон нутгийн дэд хөтөлбөрийг батлан хэрэгжилтийг зохион байгуулах" арга хэмжээ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд дэд хөтөлбөр гэсэн бодлогын баримт бичиг байхгүй учраас батлуулаагүй. Цаашид энэ заалтыг гэрээнд тусгахгүй байх саналыг хүргүүлж байна.

"Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх хамгааллын үйлчилгээний etuslamj.mn мэдээллийн санг бүрдүүлэх, тайлагнах, мэдээллээр хангах" арга хэмжээ нь Түр хамгаалах байр байхгүй тул мэдээллийн сангийн эрх өгөгдөөгүй учир тасарсан.

"Улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, Засгийн газрын тусгай сангууд болон хувийн аж ахуйн нэгж, байгууллага болон бусад хөтөлбөр, төслийн хүрээнд байнгын ажлын байр шинээр бий болгоно" гэсэн арга хэмжээний хүрээнд өмнөх онд 237 ажлын шинэ байр бий болгосон. Энэ онд шинэ ажлын байрны тоо 272 бий болгохоос 112 бий болсон нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй буюу зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

"Аймгийн хэмжээнд ХАБЭА-н урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулсан байна" гэсэн арга хэмжээний шалгуур үзүүлэлт нь үйлдвэрлэлийн осол өмнөх оноос буурсан байна гэсэн боловч энэ онд үйлдвэрлэлийн осол 5 бүртгэгдэж 0 хувьтай хэрэгжсэн гэж үнэлэгдсэн

Байгууллагуудын гамшгаас хамгаалах болон өвөлжилтийн бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулахад зөвлөмж өгөх ажил хийгдээгүй.

Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаагүй.

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон 2021 оны төлбөр болох 27,2 сая төгрөгийн санхүүжилтийг батлуулахаар удаа дараа аймгийн ИТХ-д танилцуулсан боловч Засаг даргын зардлын ангилалд байхгүй тул батлах боломжгүй гэсэн шийдвэр гарсан. Мөн сангийн яамнаас аймгуудад хуваарилсан батлагдсан төсвийн суурь зардалд тусгаагүй тул төлөх боломжгүй байна. Аймгийн төрийн сангийн хэлтсээс Сангийн яаманд хүсэлт тавьсан боловч нэгдсэн журмаар шийдвэрлэнэ гэсэн хариу өгсөн.

## **ДӨРӨВ: ГЭРЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ ЗӨВЛӨМЖ**

Аймгийн Засаг даргын гэрээгээр хүлээсэн үүргийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 6.2.3.2-т заасны дагуу 88.4 хувь буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Цаашид Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 36 хавсралтын дагуу оны эхэнд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн төлөвлөлтийн шаардлагыг ханган томьёолж, шалгуур үзүүлэлтийг оновчтой

тодорхойлон, суурь түвшин, хүрэх түвшнийг бодитой тооцон төлөвлөж батлуулах, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж байх шаардлагатай байна.

Гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол хяналт тавьж ажиллан удирдлагуудад мэдээллийг тогтмол хүргэж ажиллахыг холбогдох хэлтэс, агентлаг анхааралдаа авч ажиллах шаардлагатай байна.

Баталгаажуулсан:

Аймгийн Засаг дарга  Ц.Мөнхбат

Хянасан:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн  
даргын албан үүргийг түр орлон  
гүйцэтгэгч  Д.Даариймаа

Тайлан бичсэн:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн  
ахлах мэргэжилтэн  Э.Одончимэг